



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/82/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2022 он

*Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,*

*Тэргүүлэх аудитор: Б.Болортуул*

*Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn*

*Аудитын менежер: И.Сэмжидмаа*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn*

*Ахлах аудитор: Д.Нармандах*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn*

*Аудитор: Г.Ганцэцэг*

*Утас: 70003775,*

*Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com*

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС            Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ЗГ                 Засгийн газар

УСНББОУС        Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.25 № 279

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020961

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>17,119,942.40</u></b>	<b><u>18,524,442.40</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	17,119,942.40	18,524,442.40
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	17,119,942.40	18,524,442.40
35420	Аж ахуйн материал	11,063,000.00	10,693,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,056,942.40	7,831,442.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>129,495,450.47</u></b>	<b><u>117,387,736.88</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	129,495,450.47	117,387,736.88
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	126,495,450.47	114,387,736.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	68,556,019.54	68,556,019.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	(6,855,602.04)	(11,426,003.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,586,646.22	71,586,646.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(44,128,379.83)	(47,305,338.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,696,701.20	22,330,701.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,071,660.46)	(14,751,421.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,035,607.00	29,035,607.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,812,000.16)	(10,478,076.12)
39217	Ном	6,488,119.00	6,839,602.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,000,000.00	3,000,000.00
39301	Програм хангамж	282,000.00	282,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(282,000.00)	(282,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>146,615,392.87</u></b>	<b><u>135,912,179.28</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>146,615,392.87</u></b>	<b><u>135,912,179.28</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	146,615,392.87	135,912,179.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	110,930,574.20	110,930,574.20
51101	Өмч: - төрийн	110,930,574.20	110,930,574.20
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	10,669,318.29	(33,895.30)
51210	Өмнөх үеийн үр дүн	10,669,318.29	10,669,318.29
51220	Тайлант үеийн үр дүн	-	(10,703,213.59)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,015,500.38	25,015,500.38
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>146,615,392.87</u></b>	<b><u>135,912,179.28</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>80,286,100.00</b>	<b>83,590,500.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>80,286,100.00</b>	<b>83,590,500.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	80,286,100.00	83,590,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,286,100.00	83,590,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>86,917,643.99</b>	<b>94,663,713.59</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>86,917,643.99</b>	<b>94,663,713.59</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	83,240,990.99	93,428,790.03
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	58,983,552.00	59,445,831.44
210101	Үндсэн цалин	58,983,552.00	59,445,831.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,835,349.00	7,868,200.00
210201	Тэтгэврийн даатгал	5,386,949.00	5,490,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	490,000.00	475,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	612,100.00	594,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	122,300.00	118,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,224,000.00	1,189,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,499,226.00	5,874,552.00
210301	Гэрэл, цахилгаан	441,186.00	537,052.00
210302	Түлш, халаалт	4,992,040.00	5,337,500.00
210303	Цэвэр, бохир ус	66,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,534,940.00	4,615,210.00
210401	Бичиг хэрэг	967,500.00	853,450.00
210402	Тээвэр, шатахуун	530,520.00	1,030,330.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	609,700.00	666,930.00
210404	Ном, хэвлэл	244,320.00	45,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	880,000.00	1,649,500.00
210408	Бараа материал акталсны зардал	302,900.00	370,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	211,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	111,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	100,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	482,000.00	250,000.00
210702	Дотоод албан томилолт	482,000.00	250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	390,000.00	2,070,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	1,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	270,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,515,923.99	13,093,196.59
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,515,923.99	13,093,196.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,676,653.00	1,234,923.56
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	1,234,923.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,234,923.56

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,676,653.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,676,653.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(6,631,543.99)</b>	<b>(11,073,213.59)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	370,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	370,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	370,000.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(6,631,543.99)</b>	<b>(10,703,213.59)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	110,930,574.20	25,015,500.38	10,669,318.29	146,615,392.87
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>110,930,574.20</b>	<b>25,015,500.38</b>	<b>10,669,318.29</b>	<b>146,615,392.87</b>
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>110,930,574.20</b>	<b>25,015,500.38</b>	<b>10,669,318.29</b>	<b>146,615,392.87</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>110,930,574.20</b>	<b>25,015,500.38</b>	<b>10,669,318.29</b>	<b>146,615,392.87</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-10,703,213.59	-10,703,213.59
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>110,930,574.20</b>	<b>25,015,500.38</b>	<b>-33,895.30</b>	<b>135,912,179.28</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>80,286,100.00</b>	<b>83,590,500.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>80,286,100.00</b>	<b>83,590,500.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	80,286,100.00	83,590,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,286,100.00	83,590,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>80,286,100.00</b>	<b>83,590,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>80,286,100.00</b>	<b>83,590,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>76,609,447.00</b>	<b>82,355,576.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	58,983,552.00	59,445,831.44
210101	Үндсэн цалин	58,983,552.00	59,445,831.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,835,349.00	7,868,200.00
210201	Тэтгэврийн даатгал	5,386,949.00	5,490,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	490,000.00	475,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	612,100.00	594,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	122,300.00	118,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,224,000.00	1,189,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,499,226.00	5,874,552.00
210301	Гэрэл, цахилгаан	441,186.00	537,052.00
210302	Түлш, халаалт	4,992,040.00	5,337,500.00
210303	Цэвэр, бохир ус	66,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,419,320.00	5,135,193.00
210401	Бичиг хэрэг	1,100,000.00	1,391,950.00
210402	Тээвэр, шатахуун	530,520.00	1,030,330.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	609,700.00	666,930.00
210404	Ном, хэвлэл	299,100.00	396,483.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	880,000.00	1,649,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	1,711,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	411,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	482,000.00	250,000.00
210702	Дотоод албан томилолт	482,000.00	250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	390,000.00	2,070,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	1,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	270,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	200,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,676,653.00</b>	<b>1,234,923.56</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,676,653.00	1,234,923.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,676,653.00	1,234,923.56
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	83,244,250.00	82,355,576.44
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	83,244,250.00	82,355,576.44
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	83,244,250.00	82,355,576.44
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	59,454,180.00	59,445,831.44
210101	Үндсэн цалин	59,454,180.00	59,445,831.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,868,150.00	7,868,200.00
210201	Тэтгэврийн даатгал	5,489,620.00	5,490,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	475,690.00	475,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	594,640.00	594,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	119,030.00	118,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,189,170.00	1,189,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,388,060.00	5,874,552.00
210301	Гэрэл, цахилгаан	1,000,060.00	537,052.00
210302	Түлш, халаалт	5,388,000.00	5,337,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,139,660.00	5,135,193.00
210401	Бичиг хэрэг	1,392,100.00	1,391,950.00
210402	Тээвэр, шатахуун	1,030,360.00	1,030,330.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	667,200.00	666,930.00
210404	Ном, хэвлэл	400,000.00	396,483.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,650,000.00	1,649,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,719,200.00	1,711,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	419,200.00	411,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	600,000.00	250,000.00
210702	Дотоод албан томилолт	600,000.00	250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,075,000.00	2,070,000.00
210807	Газрын төлбөр	5,000.00	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	83,244,250.00	82,355,576.44
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	83,244,250.00	82,355,576.44
132001	Орон нутгийн төсвөөс	83,244,250.00	82,355,576.44
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор Г.Ганцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь соёл урлагаар үйлчлэх тохилог орчин бүрдүүлж, соёлын ажилтны ёс зүй, ажлын хариуцлага, ур чадварыг дээшлүүлж, иргэддээ хүрэх соёл урлагийн чанар хүртээмжийг сайжруулж, түүх соёлын өв, буриад ёс заншил, уламжлалаа дээдлэн орчин үеийн соёлыг түгээн дэлгэрүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй боловч 2018 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсөвт зардлын дүн 76,609.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,532.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,532.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Бараа материалын дансны үлдэгдэл 18,524.4 мянган төгрөг болж 1,404.5 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 201,630.6 мянган төгрөг болж 985.4 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь 985.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, номын фондоор нэмэгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 45,858.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь татварын бус орлого буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 7,746.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа ажил үйлчилгээний зардал өссөнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 83,244.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 83,244.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 83,244.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 83,244.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 83,590.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, батлагдсан төсвөөс 346.2 мянган төгрөгийн илүү санхүүжилт авч нийт 83,950.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 82,355.6 мянган төгрөг буюу 98.9 хувийн гүйцэтгэлтэй буюу 1,234.9 мянган төгрөгийн татан төвлөрүүлэх хийгдсэн буюу илүү санхүүжилт 346.2 мянган төгрөг болон үлдэгдэл 888.7 мянган төгрөг буюу 1.1 хувийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зарлага байхгүй.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган сумын Соёлын төв нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 11 орлогын 75,308.9 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээг байршуулаагүй байна. Бусад мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасны дагуу бүх шатны байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 11,900.0 мянган төгрөгийн 4 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө 2018 онд хэвлэгдсэн Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж хэрэгжүүлэх
- Дорнод аймгийн Засаг даргын тамгын газраас гаргасан Санхүү, төсвийн холбогдолтой дүрэм, журмын эмхтгэлийн дагуу хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах
- Мэргэжлийн бус нягтлан бодогчдод зориулж нягтлан бодох бүртгэлийн арга аргачлал, төсвийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг таниулсан сургалт зохион байгуулах
- НӨАТ-ын цахим төлбөрийн баримтын бараа, ажил үйлчилгээний нэр төрлийг дэлгэрэнгүй жагсаалтаар хүлээн авч төсвийн гүйлгээг хийж байх.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,662.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9,364.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 298.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тавигдсан.

### 4.1 Төлбөрийн акт

1. Эмнэлэгийн магадлагаатай, ажиллаагүй ажилтанд 227.6 мянган төгрөгийн цалин хөлс тооцон олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.2.1-т “Гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх” заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг олгож ажиллах, ажлын цагийн бүртгэлийг үнэн зөв хөтлөх, төлбөрийн акт өгөх

2. Дотоод албан томилолтын зардлыг 70.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27 ны өдрийн 301 дугаар тушаалын 1-д “Төрийн албан хаагчийн албан томилолтын зам хоногийн зардлыг суманд 12.0 мянган төгрөг, байрны зардлыг 14.5 мянган төгрөг байхаар тогтоосон”- заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дотоод албан томилолтын зардлыг олгохдоо Сангийн сайдын 301 дугаарын тушаалыг мөрдөн ажиллах, төлбөрийн акт өгөх

### 4.2 Албан шаардлага

1. МУ-ын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тоот тогтоолыг хэрэгжүүлж 8,164.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллах тухай тушаал шийдвэр гаргаагүй, дотооддоо хэмнэлтийн зохион байгуулалтыг хийгээгүй байна.

Энэ нь МУ-ын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1 -д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10 – аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”-г зөрчсөн, хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь** : Эрх бүхий дээд байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах, дотооддоо хэмнэлтийн зохион байгуулалтыг хийх, Албан шаардлага өгөх

- МУ-ын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тоот тогтоолын 1.4 -д заасан заалтын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй. 1,200.0 мянган төгрөгөөр ажлын хувцас худалдан авсан байна.

Энэ нь МУ-ын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4 -д “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”-г зөрчсөн, хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь** : Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах, Албан шаардлага өгөх

Дээрх биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сумын Соёлын төв	4	9,662.5	-	-	2	298.1	2	9,364.4	-	-